



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/243

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэнд тавих хяналтыг тогтмолжуулан өр авлагыг бууруулах, мэдээ тайланг гаргах ажлын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст 1 гэрээт ажилтныг хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлж ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

2. Гэрээт ажилтны зардлыг хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан 5277294 төгрөг /таван сая хоёр зуун далан долоон мянга хоёр зуун ерөн дөрвөн/-ийн зардлыг сар бүр ажлын үр дүнгээр тооцож санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Гантөмөр/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

4. Гэрээт ажилтанг зохих журмын дагуу томилон гэрээ байгуулан холбогдох зардлыг хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтын зардлаас олгосон санхүүжилтээс санхүүжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/243 Ch
02 01207